



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 27 өдөр

Дугаар А/34

Шивээговь сум

Гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх  
ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6.а, 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2, 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 58 дугаар зүйлийн 58.4.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн “Сумын 2020 оны төсөв батлах тухай” 11 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Гамшгаас хамгаалах хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийг хангах, хүн ам, байгалийн гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах зорилгоор сумын 2020 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих “Гамшгаас хамгаалах урьдчилан сэргийлэх ажил”-ын шууд худалдан авалтыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

Б.Баасанбат

(Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч-зөвшилцсөнөөр)

Нарийн бичгийн дарга:

З.Баасандалай

(Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

Гишүүд:

Ш.Буяннэмэх

(Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч)

О.Дөлгөөн

(Нягтлан бодогч)

Д.Эрдэнээ

(нярав)

2. Сумын “Гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх ажил”-д зарцуулагдах 1000000 /нэг сая/ төгрөгийг зарцуулсугай.

3. “Гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх ажил”-д зарцуулагдах 1000000 /нэг сая/ төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас зарцуулахыг нягтлан бодогч /О.Дөлгөөн/-д зөвшөөрсүгэй.

4212 0080

4. Худалдан авах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулж, санхүүгийн баримт бичгийн бүрдлийг хангаж ажиллахыг ажлын хэсгийн дарга /Б.Баасанбат/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЯГААНЦЭЦЭГ